



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 8/07

Мандалговь

Г Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлын үеийн мэдээ мэдээллийн чанар, хяналтыг сайжруулах тухай.

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, 12.1.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01,02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдээс авах мэдээний чанарыг сайжруулах, давхцлыг арилгах, үнэн бодит байдалд хяналт тавьж ажиллахыг холбогдох хэлтэс болон эмч, мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.
2. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлын өдөр тутмын мэдээ болох гэрийн ажиглалт, шинжилгээ, батлагдсан тохиолдол, эдгэрсэн, эмчлэгдэж гарсан, эмнэлзүйн, нас баралт, шилжсэн, орны тооны мэдээг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Л.Ганбат), Хавьтал, тандалтын багийн мэдээг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (Б.Саруулцэцэг) авч байхыг тус тус даалгасугай.
3. Өдөр бүрийн мэдээг тухайн өдрийн 16.00 цагт Эрүүл мэндийн мэдээ мэдээлэл хариуцсан мэргэжилтэн (О.Энхцэцэг)-д хугацаанд нь өгөхийг Хэлтсийн дарга (Л.Ганбат, Б.Саруулцэцэг) нарт үүрэг болгосугай.
4. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлын өдөр тутмын мэдээг нэгтгэн хяналт тавьж 17.00 цагт аймгийн Онцгой комисс болон холбогдох байгууллагад мэдээлэхийг Эрүүл мэндийн мэдээ мэдээлэл хариуцсан мэргэжилтэн (О.Энхцэцэг)-д даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга (Ц.Энхсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ   
Б.АЛТАНТӨГС

903-064 x 4816129119